**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд Нисэх буудлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2024/11/НА-СТА-ТӨА


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 99013699 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нарантуул<br>Утас:99019800 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт**

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024-03-02 № 1/108

танай 2024-02-19-ны № 19 -т

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХОВД АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН
ДАРГА Б.БОЛОРЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд аймаг дахь "Ховд" Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймаг дахь "Ховд" Нисэх буудлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор "Ховд" нисэх буудал нь 2023 онд 195 агаарын хөлөг хүлээн авч, 11,841 зорчигчдод үйлчилгээ үзүүлэн, 8,257 ширхэг ачаа тээшинд үзлэг шалгалтыг зохион байгуулж, нислэгийн аюулгүй байдал, аэродром, тоног төхөөрөмж, газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангамжийн бүрэн хангаж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд өөрийн орлогоор 5,900.0 мянга, Иргэний нисэхийн ерөнхий газраас 1,903,429.4 мянга, нийт зардлыг 1,909,329.4 мянган төгрөг байхаар батлагдаж, гүйцэтгэлээр 1,735,064.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 1,747,829.5 мянган төгрөгийг зарцуулж 841,108.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар буудал нь тайлант онд 5 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 96.6 хувийн биелэлттэй гэж дүгнэн ИНЕГ-т хүргүүлсэн байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 21,583,881.52 | 10,237,973.51 |
| 1.1.2 | Дансны авлага | 12,595,723.78 | 5,867,546.97 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 226,800.00 | 29,651.20 |
| 1.1.4 | Бусад авлага | 212,318.20 | - |
| 1.1.6 | Бараа материал | 188,922,791.34 | 208,666,920.57 |
| | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **223,541,514.85** | **224,802,092.25** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 3,589,247,679.24 | 2,749,494,161.40 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 13,297,045,942.36 | 13,279,388,884.00 |
| 1.2.7 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 51,795,479.45 | 44,919,808.05 |
| | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **16,938,089,101.05** | **16,073,802,853.46** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **17,161,630,615.90** | **16,298,604,945.71** |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 37,505.26 | - |
| | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **37,505.26** | **-** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **37,505.26** | **-** |
| **2.3** | **Эздийн өмч** | **14,978,054,752.57** | **14,118,976,376.17** |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 13,259,898,000.00 | 13,259,898,000.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,718,156,752.57 | 859,078,376.17 |
| 2.3.7 | Эздийн өмчийн бусад хэсэг | 34,650,965.64 | 12,771,666.34 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 2,148,887,392.43 | 2,166,856,903.20 |
| | **Эздийн өмчийн дүн** | **17,161,593,110.64** | **16,298,604,945.72** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **17,161,630,615.90** | **16,298,604,945.71** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан (төгрөгөөр)

| мөр | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (Цэвэр) | 53,677,773.06 | 67,624,828.17 |
| 2 | Борлуулалтын өртөг | 1,666,426,507.91 | 2,577,438,197.62 |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **(1,612,748,734.85)** | **(2,509,813,369.45)** |
| 5 | Хүүний орлого | | 140,023.56 |
| 8 | Бусад орлого | 2,491,416,226.32 | 1,757,926,301.26 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 600,000.00 | 4,320,000.00 |
| 12 | Бусад зардал | 77,785,553.03 | 85,041,820.99 |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **800,281,938.44** | **(841,108,865.62)** |
| **20** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **800,281,938.44** | **(841,108,865.62)** |

| | | | |
|---|---|---|---|
| 28 | **Нэгж хувьцааны ногдох суурь ашиг (алдагдал)** | **800,281,938.44** | **(841,108,865.62)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан (сая.төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц | Эзний өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 13,259,898,000 | 1,718,156,752.57 | 34,650,965.64 | 2,148,887,392.43 | 17,161,593,110.64 |
| 3 | **Залруулсан үлдэгдэл** | **13,259,898,000** | **1,718,156,752.57** | **34,650,965.64** | **2,148,887,392.43** | 17,161,593,110.64 |
| 9 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **13,259,898,000** | **1,718,156,752.57** | **34,650,965.64** | **2,148,887,392.43** | 17,161,593,110.64 |
| 11 | **Залруулсан үлдэгдэл** | **13,259,898,000** | **1,718,156,752.57** | **34,650,965.64** | **2,148,887,392.43** | 17,161,593,110.64 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (841,108,865.62) | -841,108,865.62 |
| 14 | Өмчид гаргасан өөрчлөлт | | (859,078,376.40) | (21,879,299.30) | 859,078,376.40 | -21,879,299.30 |
| **17** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **13,259,898,000** | **859,078,376.17** | **12,771,666.34** | **2,166,856,903.21** | 16,298,604,945.72 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Д/д | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **1,602,433,382.00** | **1,738,254,451.49** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 9,900,000.00 | 36,705,439.75 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 0 | 3,195,748.80 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 1,585,990,000.00 | 1,683,446,500.00 |
| 1.1.6 | ҮЙА-ны бусад мөнгөн орлого | 6,543,382.00 | 14,906,762.94 |
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **1,618,088,251.49** | **1,744,639,123.06** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 906,432,195.26 | 934,596,417.86 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 237,334,216.46 | 247,907,448.86 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 163,806,239.00 | 341,165,166.80 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 88,731,251.11 | 43,209,184.01 |
| 1.2.5 | Хүүний төлбөрт төлсөн | - | 14,000.99 |
| 1.2.6 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 85,001,620.00 | 27,950,100.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 128,822,029.66 | 141,460,979.63 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 7,280,000.00 | 8,230,000.00 |
| 1.2.9 | ҮЙА-ны бусад мөнгөн зарлага | 680,700.00 | 105,824.91 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-15,654,869.49** | **-6,384,671.57** |

| | | | |
|---|---|---|---|
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **-** | **140,023.56** |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | - | 140,023.56 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **-** | **5,101,260.00** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | 5,101,260.00 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-** | **-4,961,236.44** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **-15,654,869.49** | **-11,345,908.01** |
| **4** | **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **-15,654,869.49** | **-11,345,908.01** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **37,238,751.01** | **21,583,881.52** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **21,583,881.52** | **10,237,973.51** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| **Үзүүлэлт** | | **2022 оны гүйцэтгэл** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|---|
| | | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **НИЙТ ЗАРЛАГА** | | **1,618,193,251.49** | 1,909,329,400 | 1,747,829,481.30 |
| **НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,618,193,251.49** | 1,909,329,400 | 1,747,829,481.30 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ** | | **1,611,649,869.49** | **1,891,959,400** | **1,742,679,481.30** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **1,044,165,194.46** | **1,190,850,100** | **1,081,539,507.18** |
| 1 | Үндсэн ба нэмэгдэл цалин | 531,233,838.42 | 1,013,992,900 | 911,244,507.18 |
| 2 | Унаа хоолны хөнгөлөлт | 177,088,536.06 | 140,857,200 | 134,295,000 |
| 3 | Урамшуулал | 154,912,500.00 | | |
| 4 | Гэрээт ажлын цалин | 180,930,319.98 | 36,000,000 | 36,000,000 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **130,751,092.11** | **156,946,300** | **140,512,678.16** |
| 1 | Тэтгэврийн даатгал | 79,741,628.90 | 101,222,300 | 87,961,877.16 |
| 2 | Тэтгэмжийн даатгал | 10,458,189.47 | 11,908,500 | 10,905,870.00 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгал | 18,764,261.23 | 17,616,800 | 19,472,165.95 |
| 4 | Ажилгүйдлийн даатгал | 1,980,637.35 | 2,381,700 | 2,015,705.97 |
| 5 | Эрүүл мэндийн даатгал | 19,806,375.16 | 23,817,000 | 20,157,059.08 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **97,775,237.29** | **115,173,700** | **108,803,666.07** |
| 1 | Гэрэл, цахилгаан | 29,815,237.29 | 36,211,800 | 32,137,466.07 |
| 2 | Түлш, халаалт | 66,352,000.00 | 75,746,800 | 75,740,000 |
| 3 | Цэвэр, бохир ус | 1,608,000.00 | 3,215,100 | 926,200 |
| **Хангамж, бараа материалын зардал** | | **117,920,801.01** | **127,088,500** | **118,029,200.94** |
| 1 | Бичиг хэрэг | 2,578,290.00 | 3,000,700 | 2,618,700 |
| 2 | Тээвэр, шатахуун | 102,669,228.00 | 100,902,700 | 100,803,800 |
| 3 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,687,203.01 | 11,850,800 | 8,596,189.94 |
| 4 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,766,080 | 9,330,500 | 5,510,521 |
| 5 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,220,000 | 2,003,800 | 499,990 |
| **Нормативт зардал** | | **10,520,000** | **-** | **-** |
| | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,520,000 | | |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 98,112,111 | **173,044,600** | **173,648,320** |
| **Багаж, техник, хэрэгсэл** | | **98,112,111** | **87,543,100** | **85,431,810** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Тоног төхөөрөмж | 79,058,677 | 20,580,300 | 20,451,260 |
| 2 | Автомашин | | 6,837,900 | 6,829,260 |
| 3 | Аэродром | 10,936,084 | 31,604,500 | 29,772,290 |
| 4 | Гал унтраах | 8,117,350 | 28,520,400 | 28,379,000 |
| 5 | Хөдөлмөр хамгааллын зардал | | 33,885,400 | 31,250,621 |
| 6 | Урсгал засвар | | 51,616,100 | 56,965,888.80 |
| **Томилолт, зочны зардал** | | **33,993,100** | **43,286,100** | **43,135,850** |
| | Дотоод албан томилолт | 33,993,100 | 43,286,100 | 43,135,850 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **64,256,925.24** | **78,323,200** | **70,696,556** |
| 1 | Харуул, хамгаалалтын зардал | 1,629,016.00 | 6,941,000 | **1,809,052.00** |
| 2 | Үл хөдлөх хөрөнгийн татвар | 33,010,531.24 | 34,165,000 | 33,727,981.24 |
| 3 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 3,412,000 | 4,320,000 |
| 5 | Даатгалын үйлчилгээ | 7,280,000.00 | 8,239,900 | 8,230,000 |
| 6 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 1,135,500 | 1,135,500 |
| 7 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 428,480.00 | | |
| 8 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | | |
| 9 | Газрын төлбөр | 21,228,198.00 | 24,184,800 | 21,228,198 |
| 10 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 80,700.00 | 245,000 | 245,824.91 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **4,578,134.00** | **7,246,900** | **6,313,703** |
| 1 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,143,134.00 | 5,846,900 | 4,423,703 |
| | **Сургалт семинар** | | **1,400,000** | **1,890,000** |
| | Дотоод сургалт | 1,435,000.00 | 1,400,000 | 1,890,000 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **9,577,274.38** | **17,370,000** | **5,150,000** |
| Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | | 9,577,274.38 | 17,370,000 | 5,150,000 |
| 1 | Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж | | 13,850,000 | 2,750,000 |
| 2 | Эмчилгээний зардал | | 3,520,000 | 2,400,000 |
| **НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН ДҮН** | | **1,602,433,382** | **1,909,329,400** | **1,735,064,093.25** |
| **НИЙТ ОРЛОГЫН ДҮН** | | **16,443,382** | **5,900,000** | **51,617,593.25** |
| 1 | Буулт, хөөрөлтийн орлого | 9,900,000 | 2,200,000 | 51,147,569.69 |
| 2 | Зорчигч үйлчилгээний орлого | | 700,000 | |
| 3 | Бусад орлого | 6,543,382 | 3,000,000 | 470,023.56 |
| **НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН** | | 1,585,990,000 | **1,903,429,400** | **1,683,446,500** |
| | Улсын төсвөөс санхүүжих | 1,585,990,000 | 1,903,429,400 | 1,683,446,500 |

Аудитаар нийт 15,000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 15,000.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 15,000.0 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрснээс алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 3.1 Бараа материалын орлоготой холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч байгууллагад төлбөрийг нь урьдчилан шилжүүлж нүүрсийг хүлээн аваагүй, бараа материалын тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; " гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас нийлүүлээгүй нүүрсийг 2024 оны эхний улиралд багтаан авах

### 3.2 Авлагатай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Эрхэс сувд ХХК-тай " Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ" хийлгэх зөвлөх үйлчилгээнд төлбөрийг төлсөн тухайн байгууллага ажлаа гүйцэтгээгүй санхүүгийн тайланд зардлаар бүртгэсэн авлагаар тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Санхүүгийн тайланд авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** / мян.төгрөг/

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ховд Нисэх буудал | 2 | 15,000.0 | | | | | | | 2 | 15,000.0 | - | - |
| Дүн | 2 | 15,000.0 | - | - | | | | | 2 | 15,000.0 | - | - |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ховд Нисэх буудал | 2 | 15,000.0 | | | | | 2 | 15,000.0 | - | - | - | - |
| Дүн | 2 | 15,000.0 | - | - | 0 | - | 2 | 15,000.0 | - | - | - | - |

## ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | ТӨА | - | 1 | - | - | 1 | - | - | - |
| НИЙТ | | | 1 | - | - | 1 | - | - | - |